

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТСЭЭС 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНЭЭС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ**

2023-05-22

№	Зөвлөмж	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
Бодлогын баримт бичгийн талаар			
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020- 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнөөс өөрийн байгууллагад хамааралтай заалтуудыг хяналтад авч, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж, тайлагнах	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020- 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнөөс өөрийн байгууллагад хамааралтай заалтуудыг хяналтад авч, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	100
2	Бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай” А/147 дугаар захирамжид заасан үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг бодитой үнэлэх, 2000 тэмдэгтэд багтаан товч, тодорхой тайлагнах	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын 6.2.1, 6.2.2-д заасан аргачлалын дагуу товч, тодорхой тайлагнах тал дээр албан хаагчдад анхааруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
3	БББ-ын төлөвлөлтийг хийхдээ шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, хүрэх түвшингийн үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар илэрхийлж, хэмжигдэхүйцээр төлөвлөх	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа зорилт арга хэмжээнд нийцсэн, шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг тодорхойлон тайлагнах тал дээр анхааран ажиллаж байна. Бодлогын баримт бичиг -9, хууль тогтоомжийн хэрэгжилт-1, байгууллагын үйл ажиллагааны тайлан-3, байгууллагын нээлттэй байдлын тайлан-1 тус тус хэрэгжилтийг хангаж, тайлагнаж байна.	100
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн талаар			

4	Байгууллагын болон салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачлага гарган ажиллах	Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд барилгын материалын лаборатор, албан конторын барилгын 1,4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй нэг маягийн зураг төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр талаар БХБЯ, ГЗБГЗЗГ-т баримт бичгийн материал бүрдүүлэлтийг хийж, санал хүргүүлэхээр ажиллаж байна.	100
5	Төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдэд төрийн үйлчилгээний e-topuоПа системийг сурталчилж, төрийн байгууллагын дотоод удирдлагын ЕКР системийн ашиглалтыг дээшлүүлж, тоон гарын үсгийг нэмэгдүүлэх, төрийн цахим шууданг нэвтрүүлэн ашиглах. Тусгай зөвшөөрөл, өргөдөл, гомдол болон бусад шаардлагатай төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэх. Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд мэдээ, мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэхэд анхаарах	Газартай холбоотой 11 төрлийн лавлагааг E-mongolia цахим системийг ашиглан авах боломжтой болсон. Үүнд: • Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа; • Газар эзэмших эрхийн лавлагаа; • Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа; • Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт; • Газрын төлбөр, тооцоо нийлсэн акт; • Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа; • Кадастрын зураг хэвлэж авах; • Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа; • Нэгж талбарын үнэлгээний лавлагаа; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх саналаа өгөх; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг, тайлан харах Үр нөлөө: Газартай холбоотой 11 төрлийн лавлагаа үйлчилгээ E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэмэгдсэнээр иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаанаас ч өөрийн эзэмшил газрын лавлагаа үйлчилгээг E-mongolia авах боломжтой юм. -Салбарын хэмжээнд барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн баримт бичгийн бүрдэл авах, барилга байгууламжийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх зэрэг иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д нэвтрүүлээд байна. -Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг urban.gov.mn цахим системээр олгохоор үйл ажиллагааг нэвтрүүлээд байна. Мөн иргэд, олон нийтэд e-mongolia төрийн цахим системээс газартай холбоотой лавлагааг хэрхэн авах талаар 2023 оны 05 дугаар сарын 04-нөөс 2023 оны 05 дугаар сарын 06-ний өдрүүдэд зохион байгуулагдсан	100

		хөдөөгийн багуудын өдөрлөгөөр нийт 245 иргэд, олон нийтэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. -2022 онд ERP mongolia цахим системийн хүний нөөцийн удирдлага цэсний албан тушаал хэсэгт нийт 16 албан тушаалын мэдээллийг оруулж, төрийн албан хаагч хэсэгт 13 албан хаагчийн мэдээлэл болон А, Б анкетыг оруулсан. 2023 оны хагас жилийн байдлаар ERP цахим системээр ирсэн бичиг 59, явсан бичиг 26 хүлээн авч бүртгэн ажилласан байна. -Албаны тоон гарын үсгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт уламжлан байгууллагын 12 албан хаагч Үндэсний дата төвөөс 2021 онд бүрэн авсан. Иргэний тоон гарын үсгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 онд 12 албан хаагч авсан. -2021 онд байгууллагын 14 албан хаагчдад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас албаны имайл хаягийг нээсэн бөгөөд албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. -Газартай холбоотой өргөдөл, хүсэлтийг 2021 оны 10 дугаар сараас эхлэн газрын цахим сайт болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан авч байгаа бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар нийт 169 иргэн, хуулийн этгээдээс газартай холбоотой цахим өргөдөл ирүүлснээс шаардлага хангаагүй цуцалсан 36 өргөдөл, цахим өргөдөл үүсгэсэн нь 133 өргөдөл байна. Үүнээс холбогдох хуулийн хугацаанд 124 өргөдлийг шийдвэрлэн, 9 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Цахим өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлт 93.2 хувьтай байна. Шийдвэрлэлтийн график үзүүлэлтийг байгууллагын цахим хуудасны “Статистик үзүүлэлт” цэсэнд байршуулан ажиллаж байна. Мөн 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг 2023 оны 01/90 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Дээрх тайлан мэдээг байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт байршуулсан. -Байгууллагаас хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор байгууллагын www.govisumber.gazar.gov.mn сайт нь 15 үндсэн цэс болон 67 дэд цэсэнд мэдээ мэдээллүүдийг тухай бүр нь байршуулан иргэд, олон нийтэд мэдээлдэг. 2023 оны хагас жилийн байдлаар байгууллагын сайтанд нийт 75 зар, мэдээ, мэдээлэл, тайлан байршуулсан байна.Үүнд: - Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан тушаал шийдвэр 8, - Сар бүр хийсэн ажлуудын тайлан 4 удаа - Газрын харилцааны чиглэлээрх мэдээлэл 6,	
--	--	--	--

		- Барилга, хот байгуулалттай холбогдолтой 13 - Салбарын хууль тогтоомж 8 - Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүүтэй холбоотой 36 мэдээ, мэдээллийг тус тус байршуулсан байна.	
6	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх	Байгууллагын цахим хуудсанд нэмэлт хөгжүүлэлт хийн иргэн, хуулийн этгээд цахимаар өргөдөл, гомдол илгээх цэсийг нэмсэн. Мөн иргэн олон нийт байгууллагын цахим хуудсанд зочилсноор газартай газрын цахим бирж болон газрын цахим сайт болох egazar.gov.mn, төрийн нэгдсэн цахим систем болох И-Монголиа, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас руу шууд зочилж орохоор холбоосыг оруулан ажилласан.	100
7	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хуулийн хүрээнд төрийн албаны сул орон тоог нөхөж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах	Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний хөтөлбөр болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг байгууллагын даргын 2022 оны А/02 тушаалаар 4 жилийн хугацаатай баталсан. Дээрх хөтөлбөрийн дагуу жил бүр албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан мэдээллийн самбарт болон байгууллагын цахим хуудасны ил тод дэд цэсний үйл ажиллагаа цэсэнд байршуулан ажиллаж байна. Дотоод сургалтын төлөвлөгөөг 4 үндсэн сэдвийн хүрээнд 52 сургалтын сэдэвтэй, нийгмийн баталгааг 18 арга хэмжээтэйгээр байгууллагаар 2023 оны 03 дугаар сард батлуулан ажилласан. -Байгууллагын хэмжээнд 3 сул орон тоо байгаа бөгөөд сул орон тооны захиалгыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажилласан. Мөн байгууллагын /govisumber.gov.mn/ сайтанд мэдээллийг тухай бүр нь шинэчлэн байршуулсан. -Байгууллагын 15 албан хаагчдаас 1 албан хаагч 20-с дээш, 4 албан хаагч 10-с дээш, 10 албан хаагч 2 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.	100
8	Аймаг, сумын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, Шадар сайдтай аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулж, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, сайдын гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэгт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, үр дүнтэй ажиллах тал дээр анхаарч төлөвлөгөө удирдамж боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний талаар			

9	Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд мэдээ, мэдээллийг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль болон Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт” тогтоолын дагуу мэдээлж, тогтмол шинэчилж байх	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийн дагуу байгууллагын цахим хуудсанд тухай бүр холбогдох мэдээ, мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэсээс манай байгууллагын цахим хуудасны ил тод байдалд дээрх тогтоолоор батлагдсан мэдээллийн ил тод байдлаар шалгалт хийсэн бөгөөд 86.7 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Байгууллагын https://govisumber.gazar.gov.mn/ цахим сайт болон Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Говьсүмбэр аймаг Газрын алба зэрэг байгууллагын цахим хаяг facebook-д байршуулснаас гадна аймгийн Borjigin nutag mini facebook болон аймгийн бусад зарын группуд, Баянтал сум, Шивээговь сумдын нэгдсэн Facebook группд барилгын салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд ил тод мэдээллэн ажиллаж байна. Жишээлбэл: -Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлын хэрэгжилт, -Газрын багц хууль болон геодези, зураг зүйн тухай хууль, хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найгуулгын төслийн хэлэлцүүлэг - “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төлөвлөлтийн танилцуулга, хэлэлцүүлэг - Хот байгуулалтын кадастрын цахим системийнн мэдээлэл - Аймгийн хэмжээнд “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-ий мэдээлэл -“Биологи цэвэрлэгээний процесс” сэдэвт сургалтын мэдээлэл - Орон сууцны эрэлт хэрэгцээ тодорхойлох судалгаа - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн мэдээлэл - Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах баримт бичиг бүрдүүлэлтийн мэдээлэл - Хөрөнгө оруулалтын 7 ажлын мэдээлэл зэргийг байршуулж, ил тодын самбарт дээрх мэдээллүүдийг тус тус байршуулан ажилласан.	100
---	--	---	-----

10	Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулах	Байгууллагын www.govisumder.gazar.gov.mn цахим сайтын төсөв санхүү болон статистик цэсэнд нийт 12 ширхэг, шилэн дансны www.shilendans.gov.mn цахим сайтанд нийт 58 ширхэг мэдээллийг хүснэгтэн болон график үзүүлэлтээр, мөн байгууллагын ил тодын самбарт тус тус ил тод байршуулсан.	100
11	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой баримт бичгийн жагсаалт болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм журмыг цахим хуудсанд байршуулах	Газартай холбоотой төрийн үйлчилгээ авахтай холбоотой бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг байгууллагын цахим хуудас болон www.govisumber.gazar.gov.mn сайтын газрын хэлтэс дэд цэсний өргөдөл маягт цэсэнд болон газартай холбоотой цахим хүсэлт илгээх баримт бичгийн жагсаалт цэсэнд байршуулан ажилласан.	100
12	Өргөдөл, гомдол санал хүсэлтийн шийдвэрлэлтийг хяналтын картанд бичиж хэвших, бүртгэлийн дэвтрийг бүрэн бөглөх	2023 оны хагас жилийн байдлаар Албан хэрэг хөтлөлт, архив хариуцсан ажилтанд 32 ширхэг өргөдөл ирсэн бөгөөд тухай бүр хяналтын карт хийн ажиллаж байна. Мөн ирсэн өргөдөл гомдлыг бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн ажиллаж байна. Өргөдөл гомдлын тайлан мэдээг 1 дүгээр улирлыг гарган Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. 2023.03.21-ны 01/90 албан бичгээр 2023 оны 05 дугаар сарын 10-ний байдлаар 101 өргөдөл хүсэлт ирүүлснээс 98 өргөдөл шийдвэрлэгдсэн. 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа ажиллаж байна. шийдвэрлэлтийн хувь 99,8%-тай байна.	100
13	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь оруулж байх	www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь нийт 58 ш мэдээллийг бүрэн байршуулан ажилласан.Үүнд: ❖ Сар бүр цэсэнд 20ш ❖ Жил бүр цэсэнд 3ш ❖ Тухай бүр цэсэнд 35ш мэдээллийг тус тус байршуулсан.	100
14	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах	Байгууллагын 2023 оны жилийн нийт батлагдсан төсөв 405,119.4 мян.төг, 4 дугаар сарын 30-ний байдлаар нийт төсөв 136,067.1 мянган төг, гүйцэтгэл өссөн дүнгээрээ 116,143.5 мян.төг, хэмнэгдсэн төсөв 19,924.1 мян.төг. Нийт төсвийн хэмнэлтийг зардлын зүйл бүрээр харуулбал: - Цалин хөлс 15,073.7 мян.төг 3 албан хаагч ажил хавсран гүйцэтгэж байгаа, 1 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа зэргээс цалин хэмнэгдсэн. - Ажил олгогчоос олгох НДШ 1,045.6 мян.төг - Байр ашиглалттай холбоотой зардал 1,315.5 мян.төг /байгууллагын цэвэр, бохир ус, цахилгааныг хэмнэж ажилласан. - Эд хогшил, урсгал засвар 10.0 мян.төг - Албан томилолтын зардал 185.2 мян.төг	100

		• Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 3.2 мян.төг • Бараа үйлчилгээний бусад зардал буюу барилга, техник хяналтын зардал 1,683.7 мян.төг • Ажил олгогчоос олгох тэтгэмж, тусламжийн зардал 607.2 мян.төг /тайлант хугацаанд тус зардал гараагүй/ Төсөв хэмнэсний үр дүнд тайлант хугацаанд өглөг, авлага үүсгээгүй ажилласан.	
15	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт уламжлан байгууллагын 12 албан хаагчид тоон гарын үсгийг авч, албан хаагч бүрийн компьютерт Esign инсталлыг суулган ашиглаж байна. Хур, Дан системд холбогдсон байгууллагатай хамтран ажиллах гэрээг дээд шатанд байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: - Татварын ерөнхий газар - Улсын бүртгэлийн ерөнхий газар - ШШГЕГ - Банк - Нотариат - Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагууд хамтран ажиллаж мэдээлэл солилцохоор гэрээ байгуулан ажиллаж байна. Үр нөлөө: Ингэснээр газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, зардал чирэгдэлгүйгээр хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлж үйлчилгээг шуурхай үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал: Татварын хэлтэст газрын төлбөрийн ногдуулалтыг хийж, нэхэмжлэхийг цахимаар хүргүүлэх, Улсын бүртгэлийн Э, А дугаарыг цахимаар манай байгууллага шууд авах, банк лавлагааг харах, нотариатын гэрээ цахимаар харах зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж хэвшсэн.	100
16	Төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх. Ёс зүйн зөвлөлийг журмын дагуу ажиллуулж, үйл ажиллаа, үр дүнг цахим хуудсанд мэдээлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудсанд “Ёс зүйн зөвлөл” цэсэнд болон “Хууль, дүрэм, журам” цэсэнд тус тус байршуулахаас гадна дотоод удирдлагын ABLE программын олон нийт цэсэнд татаж авах боломжтойгоор байршуулсан. Жилийн эцсийн байдлаар байгууллагын Ёс зүйн зөвлөлөөс албан хаагчдад цахимаар 3, танхимаар 2 удаа сургалт хийн ажилласан. Үүний үр дүнд албан хаагчид ёс зүйн зөрчил дутагдлын талаар мэдлэг мэдээлэлтэй болж урьдчилан сэргийлж чадаж байна.	100
17	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор байгууллагын даргаар ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон сургалтын	100

		төлөвлөгөөг батлуулан байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан Төр, хувийн хэвшлийн тухай хуулиар албан хаагчид өөрт оноогдсон сэдвээр 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр сургалт хийн асуулт асуух болон харилцан ярилцах зэрэг үр дүнтэй сургалт болсон. Байгууллагын 15 албан хаагчдаас 1 албан хаагч 20-с дээш, 4 албан хаагч 10-с дээш, 10 албан хаагч 2 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.	
18	Хуулийн хүрээнд төрийн албаны сул орон тоог зарлан, нөхөж, зөрчилтэй томилгоог арилгах, холбогдох мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Байгууллагын хэмжээнд 4 сул орон тоо байгаа бөгөөд сул орон тооны захиалгыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажилласан. Мөн байгууллагын /govisumber.gov.mn/ сайтанд мэдээллийг тухай бүр нь шинэчлэн байршуулсан Үүний үр дүнд 1 сул орон тоо нөхөгдөж, ажлын бүтээмж сайжирч байна.	100
19	Төрийн албан хаагчдыг томилсон, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан тухай дүгнэлт болон төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гаргасан шийдвэрүүдийг цахим хуудсанд ил тод байршуулах	2022 онд мерит зарчмын хүрээнд Шивээговь сумын газрын даамал Э.Баярмагнай нь Газрын удирдлагын хэлтсийн даргаар албан тушаал дэвшин ажиллахтай холбогдуулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулсан 2022 оны 05/785 тоот дүгнэлтийг байгууллагын цахим хуудасны ил тод цэсний авлига ашиг сонирхол хуудсанд байршуулсан. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүд болон 2023 оны сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөө зэргийг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаа цэсэнд тус тус байршуулсан.	100
20	Төрийн байгууллагын хүний нөөцийн нэгдсэн системийн үйл ажиллагааг хангаж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэн, тухай бүр өөрчлөлт, баяжилтыг хийх, байгууллагын албан хаагчдын танилцуулга, мэдээллийг цахим хуудсанд байршуулах	ХНУМТ цахим системд 17 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулсан бөгөөд албан хаагчдын цалингийн мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж 2023 онд Зэрэг дэвийн нэмэгдэл-5 албан хаагч, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл-1 албан хаагчийн нэмэгдлийг цахим системд оруулан ажилласан. Мөн албан хаагчдын хувийн хэргийг бүрдүүлэн, хувийн хэрэгт баяжилт хийн хувийн хэрэг бүрийг кодолж дугаарласан. Байгууллагын албан хаагчдын албан тушаал, утасны дугаарыг шинэчлэн гаргаж байгууллагын цахим хуудасны хүний нөөц цэсэнд болон мэдээллийн самбарт байршуулсан.	100
21	Байгууллагын бүтэц, орон тоог хууль, тогтоомжийн хүрээнд тогтоож, бүтэц орон тооны дагуу албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр хүний нөөцийн үйл	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 тоот тушаалын дагуу байгууллагын даргын 2023 оны А/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоо, цалин санг баталсан. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын албан	100

	ажиллагааг зохион байгуулах, холбогдох мэдээ, мэдээллийг ил тод байршуулах	тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөл 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 360 дугаар тогтоол, Газрын даамлын албан тушаалын тодорхойлолтыг 361 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1-д “Албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргаж, албан тушаал тус бүрээр батална” гэж заасны дагуу байгууллагын даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 тоот тушаалаар албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлан байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан.	
22	Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд батлан мөрдүүлэх. Дотоод журмын хэрэгжилтийг ил тод мэдээлэх	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, бусад хуульд нийцүүлэн гаргаж байгууллагын дотоод удирдлагын цогц систем болох able программын олон нийтийн файлын санд байршуулан албан хаагчдаас санал авсны дагуу газрын даргын 2022 оны А/07 тоот тушаалаар баталж байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан.	100
Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээний талаар			
23	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих ажилд идэвхтэй оролцох, шаардлагатай төсвийг 2023 оны төсөвт тусгах	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай байгууллага 2023 онд нийт 114 ширхэг мод 375,000 төгрөгийн зардлаар тарьж, арчилж байна. Аймгийн Засаг даргаас өгөдсөн үүргийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр нийт 240,000 төгрөгийн өртөг бүхий 60 ширхэг модыг Ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьсан 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нийт 135,000 төгрөгийн өртөг бүхий 54 ширхэг модыг байгууллагынхаа хуваарьт талбайд тарьсан байна. Үүнд: ➢ 60 ширхэг хайлаас Ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьсан. ➢ 54 ширхэг хайлаас Байгууллагынхаа хуваарьт талбайд тарьсан	100
24	Хариуцсан талбайд нөхөн тарилтыг 100 хувь хийж, ногоон байгууламжийн усалгааг тогтмолжуулж, ургалт амьдралтын хувийг нэмэгдүүлэх	Байгууллагын хариуцсан талбайн хог хаягдлыг цэвэрлэж, тогоог сэргээх, усалгааг хийх, нөхөн сэргээх, хашаа хайсыг янзлах, хамгаалах арга хэмжээг авч ажилласан. 2023 оны хагас жилд усалгааг нийт 3 удаа хийсэн байна. - 2023 оны 05 дүгээр сарын 05-ны өдөр - 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр - 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр цэнэг усалгааг тус тус хийж гүйцэтгэсэн.	100
25	Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг цахимжуулж, e-mongolia систем болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх арга	Газартай холбоотой 11 төрлийн лавлагааг E-mongolia цахим системийг ашиглан авах боломжтой болсон. Үүнд: • Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа; • Газар эзэмших эрхийн лавлагаа;	100

	хэмжээг авч хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээний e-mongolia системийг сурталчлах	- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа; - Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт; - Газрын төлбөр, тооцоо нийлсэн акт; - Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа; - Кадастрын зураг хэвлэж авах; - Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа; - Нэгж талбарын үнэлгээний лавлагаа; - Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх саналаа өгөх; - Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг, тайлан харах -Салбарын хэмжээнд барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн баримт бичгийн бүрдэл авах, барилга байгууламжийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх зэрэг иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д нэвтрүүлээд байна. - Мөн иргэд, олон нийтэд e-mongolia төрийн цахим системээс газартай холбоотой лавлагааг хэрхэн авах талаар 2023 оны 05 дугаар сарын 04-нөөс 2023 оны 05 дугаар сарын 06-ний өдрүүдэд зохион байгуулагдсан хөдөөгийн багуудын өдөрлөгөөр нийт 245 иргэд, олон нийтэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Төрийн үйлчилгээг цахимжуулж зорилгоор e-mongolia систем болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлж иргэдэд төрийн үйлчилгээний e-mongolia системийг сурталчлан таниулах үйл ажиллагаа явуулж байна. Үүний үр дүнд иргэдэд цаг хэмнэх, иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаанаас ч өөрийн эзэмшил газрын лавлагаа үйлчилгээг E-mongolia авах боломжтой юм.	
26	Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг дээшлүүлэх	2022 онд ERP mongolia цахим системийн хүний нөөцийн удирдлага цэсний албан тушаал хэсэгт нийт 16 албан тушаалын мэдээллийг оруулж, төрийн албан хаагч хэсэгт 13 албан хаагчийн мэдээлэл болон А, Б анкетыг оруулсан. 2023 оны хагас жилийн байдлаар ERP цахим системээр ирсэн бичиг 59, явсан бичиг 26 хүлээн авч бүртгэн ажилласан байна. Газартай холбоотой 11 төрлийн лавлагааг E-mongolia цахим	100

		системийг ашиглан авах боломжтой болсон. Үүнд: • Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа; • Газар эзэмших эрхийн лавлагаа; • Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа; • Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт; • Газрын төлбөр, тооцоо нийлсэн акт; • Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа; • Кадастрын зураг хэвлэж авах; • Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа; • Нэгж талбарын үнэлгээний лавлагаа; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх саналаа өгөх; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг, тайлан харах Үр нөлөө: Газартай холбоотой 11 төрлийн лавлагаа үйлчилгээ E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэмэгдсэнээр иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаанаас ч өөрийн эзэмшил газрын лавлагаа үйлчилгээг E-mongolia авах боломжтой юм.0	
27	Тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ болон байгууллагын дотоод удирдлагын цахим системийн үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах	Албаны тоон гарын үсгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт уламжлан байгууллагын 12 албан хаагч Үндэсний дата төвөөс 2021 онд бүрэн авсан. Иргэний тоон гарын үсгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 онд 12 албан хаагч авсан.	100
28	Үндэсний дата төвөөс олгосон домайн хаягийг ашиглах, албан хаагчдад албан ёсны төрийн цахим хаяг нээж, төрийн цахим шууданг нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулах	2021 онд байгууллагын 14 албан хаагчдад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас албаны имайл хаягийг нээсэн бөгөөд албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. Мөн тус онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас албаны домайн хаягийг нээж өгсөн.	100
29	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон бусад шаардлагатай төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэх	Газартай холбоотой өргөдөл, хүсэлтийг 2021 оны 10 дугаар сараас эхлэн газрын цахим сайт болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан авч байгаа бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар нийт 169 иргэн, хуулийн этгээдээс газартай холбоотой цахим өргөдөл ирүүлснээс шаардлага хангаагүй цуцалсан 36 өргөдөл, цахим өргөдөл үүсгэсэн нь 133 өргөдөл байна. Үүнээс холбогдох хуулийн хугацаанд 124 өргөдлийг шийдвэрлэн, 9 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Цахим өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлт 93.2 хувьтай байна. Мөн 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг 2023 оны 01/90 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газарт	100

		хүргүүлэн ажилласан. Дээрх тайлан мэдээг байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт байршуулсан.	
30	Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд мэдээ, мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэхэд анхаарах	Байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулах болон иргэд, олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор 2022 онд статистикийн үзүүлэлт, бодлогын баримт бичгийн тайлагналт зэрэг үндсэн цэсүүдийг нэмж мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна. Үүнд: • Статистикийн үзүүлэлт цэсэнд-31 • Бодлогын баримт бичгийн тайлагналт цэсэнд-14 тайлан мэдээг байршуулан ажилласан. Мөн албан тушаалын тодорхойлолт, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлсэн үнэлгээ, албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, тэргүүлэх чиглэл, чиг үүрэг зэрэг туслах цэснүүдийн нэмж мэдээ, мэдээллийг байршуулан ажиллаж байна.	100
31	Эзэмшил газар болон хариуцсан талбайн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр байлгах асуудлыг бүрэн хариуцах	Эзэмшил газар болон хариуцсан талбайн цэвэрлэгээг тогтмол хийн мэдээг “Хоггүй Сүмбэр” пэйж хуудаст оруулан ажиллаж байна. Үүнд: - 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр байгууллагын ойр орчмын 50 метр газрын хог хаягдлыг цэвэрлэсэн байна. - 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр байгууллагын хуваарьт талбайг цэвэрлэсэн. - 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгууллагын хуваарьт болон лабораторын арын талбайг цэвэрлэсэн. - 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын лабораторийн хойд талбайн хогийг цэвэрлэсэн. - 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр байгууллагын хуваарьт талбайн хогийг цэвэрлэсэн. - 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр байгууллагын хуваарьт талбайн хогийг цэвэрлэсэн. - 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр байгууллагын хуваарьт талбайн хогийг цэвэрлэсэн. - 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгууллагын хуваарьт талбайн хогийг цэвэрлэсэн. - 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр мод тарьдаг хуваарьт талбай болон байгууллагын хуваарьт талбайн хогийг цэвэрлэсэн.	100
32	Хог ангилан ялгадаг хогийн савтай болох	Хог ангилан ялгах хогийн савыг 90.000 төгрөгийн зардлаар шийдвэрлэж байгууллагын дотор байршуулсан.	100

			
Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр			
33	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Хот, хөдөөгийн сэргэгтийн бодлогын зорилт, арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулж, томоохон аж ахуйн нэгжийн салбарыг орон нутагт байгуулахад газрын бодлогоор дэмжин ажиллах	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын зорилтын хүрээнд байгууллагын хэмжээнд 8 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд хотоос хөдөө рүү хүн амын шилжих хөдөлгөөнийг сайжруулах, орон сууц, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт шинэчлэлт хийж орон сууц, хөнгөн үйлдвэрлэлийн бүсчлэлийг шинэчлэн тогтоох ажилд байгууллагын зүгээс санал санаачлага гарган ажиллаж байна.	100
34	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах, чанарыг хангуулах, иргэдэд хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын гүйцэтгэлийн мэдээллийг цахимаар болон бусад хэлбэрээр тогтмол хүргэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа авто замын ажил 2, барилга угсралтын ажил 6, шинээр эхэлж байгаа тохижилтын ажил 1, засварын ажил 2, дэд бүтцийн ажил 2 нийт 13 ажилд барилга захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Захиалагчийн хяналтын үе шатны ажил болон байнгын ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээллийг байгууллагын https://govisumber.gazar.gov.mn/ цахим сайт болон Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Говьсүмбэр аймаг Газрын алба зэрэг байгууллагын цахим хаяг facebook-д байршуулж цахимаар мэдээллэн ажиллаж байна.	100
35	Газар өмчлөлийн үйл ажиллагааг иргэдэд хүртээмжтэй, ил тод байдлаар зохион байгуулах. Газрын хянан баталгааны үр дүнг сайжруулах. Гэрээг дүгнэж, шаардлагатай тохиолдолд газар эзэмших, ашиглах эрхийг цуцлах	-Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолоор 4.9696 га газрыг иргэдэд өмчлүүлэхээр батлагдсан. Үүнээс Баянтал суманд шинээр өмчлүүлэх 58 иргэний 4.76 га, эзэмшил газраа өмчлөх 1 иргэний 0,07 га, Сүмбэр суманд эзэмшил газраа өмчлөх 2 иргэний 0,1396 га газруудыг тус тус баталсан байна. Баянтал суманд шинээр өмчлүүлэх иргэдийн материалыг 6 сард авахаар төлөвлөн ажиллаж байна. - Аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай 1294 нэгж талбарын судалгааг гаргаж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх хуудсыг тараах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:	100

		- Сүмбэр суманд- 984 нэгж талбар - Баянтал суманд- 112 нэгж талбар - Шивээговь суманд- 198 нэгж талбар байна. Үүний үр дүнд 903 нэгж талбарт захиалгат хянан баталгааг хийлгэх мэдэгдэл хүргүүлж, өссөн дүнгээр 2023 оны хагас жилийн байдлаар 258 нэгж талбарын хянан баталгааг цахимаар ирүүлснийг баталгаажуулаад байна. -Аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар 35 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрээг дүгнэн ажилласан байна. Үүнээс 5 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших гэрээ хангалтгүй дүгнэгдэн дараа жилийн гэрээ дүгнэлтээр зөрчлөө арилгах тухай тэмдэглэл үйлдэн ажилласан.	
36	Чойр хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, Сүмбэр суманд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 02 сарын 01-ны өдрийн А/26 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт байгууллагас оролцон ажиллаж хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу олгогдсон газар олголт болон бүтээн байгуулалт, цаашид төлөвлөлт хийх шаардлагатай байршил зэрэгт судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгч, санал дүгнэлтийн 2023.05.31-ны өдөр аймгийн ИТХ-р батлуулж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах сонгон шалгаруулалтын ажлыг зарлахаар төлөвлөөд байна.	100
37	Нийтийн эзэмжлийн орон сууцнуудын ашиглалтыг сайжруулах, СӨХ-ийг чадавхжуулах, нэмэгдүүлэхэд анхаарах	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл, мэдээллийг mcis.gov.mn цахим ситемд бүртгэлжүүлсэн байна. Нийт 4 сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл хийгдсэн. Бүртгэл мэдээллийн АЗДТГ-ын ХБТХО-н хэлтэст хариуцан хийж байна. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, тогтмолжуулах, үнийн тарифыг нэмэгдүүлэх, Сүмбэр сумын 3-р багийн “Бадрах-70”СӨХ-н зөвлөлийн гишүүдийг өөрчлөн томилох зэрэг асуудалуудыг үе шаттайгаар шийдвэрлэх ажлыг холбогдох байгууллагуудын төлөөллүүд хуралдан санал солилцон ажиллаж байна.	100
38	Аймаг, сумдын төвийн хот тохижилтыг сайжруулахад чиглэсэн бодлого, зрга хэмжээг төлөвлөн, арга зүйгээр хангаж ажиллах	Сүмбэр сумын 1,2 дугаар багт ОНХС-н 190,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 30*40 харьцаатай тохижилтийн ажлын тоо хэмжээ, төсөвт өртөг гаргах ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамран ажилласан.	100
39	Эрчим хүч, инженерийн дэд бүтэц хариуцсан байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хамтран ажиллах, салбар хоорондын уялдааг хангаж ажиллах	-2023 онд ашиглагдаж буй шугам сүлжээний ажлыг хот байгуулалтын кадастрын системд бүртгэх ажлыг аймгийн Цахилгаан түгээх сүлжээтэй хамтран зурагаар тулгалт хийж, мэдээллийн санд бүрэн бүртгэлжүүлж гадна цахилгаан хангамжийн 55040м агаарын шугам, кабель шугам 5580м трассыг нэмж бүртгэх, 15800м агаарын шугам, 1700м кабель буулгасан	100

		шугамыг бүртгэлээс хасах тооцоолол гарч, ажлыг зохион байгуулан ажиллаж байна. -Мөн “Ус-Ду”ОНӨААТҮГ-т 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр аймгийг Төрийн банктай хамран эпотекийн зээл болон салбарын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагатай холбогдолтой дүрэм журамын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, санал солилцон ажиллаж, 29 хүн хамрагдсан.	
40	Аймгийн хэмжээнд барилга, байгууламжийг паспортжуулах ажлыг эрчимжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх	2023.03.07-ны өдрийн 01/78 албан бичгээр аймгийн хэмжээнд хийгдсэн барилга байгууламжийн паспортжуулалтын ажлын судалгаа мэдээллийг гарган Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Судалгаагаар нийт 27 объектод паспортжуулалтын ажил 2019-2022 онд хийгдсэн байна. Үүний үр дүнд суурилан 1 барилгыг хүчитгэх шаардлагатай гэж үзэн зураг төсөл хийгдсэн. 1 барилгыг ашиглалтын шаардлага хангахгүй тул 2 дугаар сургуулийн барилгыг шинээр бариулан үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна. 2023 оны III улиралд паспортжуулалт хийгдсэн барилгуудад үе шаттай арга хэмжээ авах талаар санал боловсруулан ажиллахаар төлөвлөсөн.	100
Нийт дүн		100%	

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

Б.ОТГОНЧИМЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ,
АРХИВ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Т.УРАНТОГОС